



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН  
ТУШААЛ

2001 оны 8 дугаар  
сарын 14-ны өдөр

Дугаар 256

Улаанбаатар  
хот

Гадаадад суралцуулах тухай

2001-2002 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2001 оны ХЭГ/1334 дугаар албан тоотыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Жалбаа овогтой Батмагнайг Англи улсын Эксэтэрийн Их сургуулийн магистрантурт Олон улсын бизнесийн эрх зүйн чиглэлээр 1 жилийн хугацаагаар 2001-2002 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

*Батмагнай*

А.ЦАНЖИД

*Хуучин*

*үрэг*

*ТЗХАТ. 2001.8.15.*